



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2017 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРАЛ

Улаанбаатар 2017


Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 3 сарын өссөн дүнгээр 665 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19.1 хувиар буурсан байна. Харин гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 65.4 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.0 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Гэмт хэргийн тоо, оны эхний 3 сарын байдлаар

Сар	Бүх хэрэг		Өсөлт, бууралт хувиар	Илрүүлэлт, хувиар	
	2016	2017		2016	2017
1	299	252	84.3	59.7	46.9
2	525	460	87.6	62.2	59.4
3	822	665	80.9	63.4	65.4

Оны эхний нэгдүгээр сард 252 гэмт хэрэг гарсан нь өнгөрсөн оны нэгдүгээр сараас 47 хэргээр буюу 15.7 хувиар буурсан байна. Хоёрдугаар сард гарсан гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 65 хэргээс буюу 12.4 хувиар буурчээ.

Зураг- 1. Гэмт хэргийн тоо, сараар



2017 оны эхний улиралд гарсан гэмт хэргийн тоог төрлөөр харвал хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 216 гарсан нь өмнөх оны мөн үеэс 8 гэмт хэргээр буюу 5.3 хувиар буурсан байна. Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 13 гарсан нь өмнөх оны мөн үетэй адил байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 304 гарсан нь өмнөх оны мөн үеэс 142 гэмт хэргээр буюу 31,8 хувиар буурсан байна. Нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 200 нь буюу 65.8 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлсан гэмт хэрэг эзэлж байна.

Хүснэгт 2. Гэмт хэргийн тоо,төрлөөр

Үзүүлэлт		Он /сар	1	2	3
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг бүгд		2016	92	151	228
		2017	95	155	216
		Өөрчлөлт	103.3	102.6	94.7
Бүгдээс:	Хүнийг алах	2016	4	5	7
		2017	3	3	7
		Өөрчлөлт	75	60	100
	Бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг	2016	9	9	1
		2017	3	7	2
		Өөрчлөлт	33.3	77.8	200
	ББМГУ хэрэг	2016	78	136	208
		2017	89	145	197
		Өөрчлөлт	114.1	106.6	94.7
Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууний эсрэг хэрэг бүгд		2016	6	10	13
		2017	1	9	13
		Өөрчлөлт	16.7	90	100
Үүнээс:	Хүчиндэх	2016	4	8	10
		2017	0	5	5
		Өөрчлөлт	0	62.5	50
Өмчлөх эрхийн эсрэг хэрэг бүгд		2016	157	289	446
		2017	106	211	304
		Өөрчлөлт	67.5	73.0	68.2
Үүнээс:	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	2016	126	236	353
		2017	69	133	200
		Өөрчлөлт	54.8	56.4	56.7
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг хэрэг бүгд		2016	21	39	59
		2017	18	37	53
		Өөрчлөлт	85.7	94.9	89.8
Үүнээс:	Танхайрах	2016	21	39	58
		2017	18	37	53
		Өөрчлөлт	85.7	94.9	91.4
Хүн амын эрүүл мэндийн эсрэг хэрэг бүгд		2016	6	8	15
		2017	5	7	13
		Өөрчлөлт	83.3	87.5	86.7


Тайлант хугацаанд нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 53 гарсан нь өмнөх оны мөн үеэс 6 гэмт хэргээр буюу 10.2 хувиар цөөн байна. Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 13 гарсан нь өмнөх оны мөн үеэс 2 гэмт хэргээр цөөн байна.

Хүснэгт 3. Гэмт хэргийн тоо, хэргийн ангиллаар

Сар	Хөнгөн		өсөлт, бууралт	Хүндэвтэр		өсөлт, бууралт	Хүнд		өсөлт, бууралт	Онц хүнд		өсөлт, бууралт
	2016	2017		2016	2017		2016	2017		2016	2017	
1	112	136	121.4	168	94	56.0	14	19	135.7	5	3	60.0
2	212	223	105.2	279	189	67.7	26	41	157.7	8	7	87.5
3	330	309	93.6	438	292	66.7	40	51	127.5	14	13	92.9

Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийг ангилж харвал 2017 оны гарсан нийт гэмт хэргийн 46.5 хувь нь хөнгөн гэмт хэрэг, 43.9 хувь нь хүндэвтэр гэмт хэрэг байна. Нийт гэмт хэргийн 10 орчим хувийг хүнд болон онц хүнд гэмт хэрэг эзэлж байна.

Зураг- 2. Гэмт хэргийн тоо, ангилалаар, хувиар, 2016.03 сар




Тайлан хугацаанд гарсан гэмт хэргээс хүнд гэмт хэргийн тоо 51 байгаа өмнөх оны мөн үеэс 11 гэмт хэргээр буюу 27.5 хувиар өссөн байна. Оны эхний 2 сард гарсан хүнд гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 57.7 хувиар нэмэгдсэн байна. Хөнгөн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өссөн байна.

2016 онд гарсан нийт хэргийн 40.1 хувь нь хөнгөн гэмт хэрэг, 53.3 хувь нь хүндэвтэр гэмт хэрэг байна. Хүнд болон онц хүнд гэмт хэрэг нийт гэмт хэргийн 7 орчим хувийг эзэлж байсан байна.

2016 оны I улиралд хүндэвтэр гэмт хэрэг 438 гарсан нь нийт гэмт хэргийн 53.3 хувийг эзэлж байсан бол 2017 онд 292 гэмт хэрэг хүндэвтэр гэмт хэргийн ангилалд орсон нь өмнөх оны мөн үеэс 146 гэмт хэргээр буюу 33.3 хувиар буурсан байна.

Зураг- 3. Гэмт хэргийн тоо, ангилалаар, хувиар, 2017.03 сар




2017 оны эхний улиралд гарсан гэмт хэргийг цагаар ангилж харвал нийт гэмт хэргийн 21.8 хувь нь 06-14 цагийн хооронд, 27.8 хувь нь 14-19 цагийн хооронд, 17.6 хувь нь 19-22 цагийн хооронд, 32.8 хувь нь 22-06 цагт гарчээ. 2016 оны мөн үед нийт гэмт хэргийн 33.6 хувь нь 14-19 цагийн хооронд, 30.2 хувь нь 22-06 цагт гарсан байна.

Хүснэгт 4. Гэмт хэргийн тоо, хэрэг гарсан цагаар

Сар	06-14 цаг			14-19 цаг			19-22 цаг			22-06 цаг		
	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт
1	64	51	79.7	109	71	65.1	40	39	97.5	86	91	105.8
2	103	97	94.2	186	128	68.8	78	81	103.8	158	154	97.5
3	176	145	82.4	276	185	67	122	117	95.9	248	218	87.9

Зураг- 4. Гэмт хэргийн тоо хэрэг гарсан цаг, хувиар 2017.03 сар



Тайлант хугацаанд 06-14 цагт 145 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 31 гэмт хэргээр буюу 17.6 хувиар, 14-19 гарсан гэмт хэрэг 185 байгаа нь өмнөх оны мөн үеэс 91 гэмт хэргээр буюу 33.0 хувиар, 19-22 цагт гарсан гэмт хэрэг 4.1 хувиар, 22-06 цагт гарсан гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 3 гэмт хэргээр буюу 12.1 хувиар тус тус буурсан байна.

Ихэнх гэмт хэрэг нь өдрийн 14-19 цаг, шөнийн 22-06 цагийн хооронд гарсан бөгөөд гэмт хэргийн төрлөөс хамааран цаг хугацааг нарийвчлан тогтоох хэрэгтэй.


Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн 17.3 хувь нь Даваа, Баасан гарагт, 12.2 хувь нь Бямба, Ням гарагт, 14 орчим хувь нь Мягмар гарагт, 12.5 хувь нь Лхагва гарагт 14.5 хувь нь тус тус гарсан байна.

Хүснэгт 5. Гэмт хэргийн тоо, гэмт хэрэг үйлдсэн гаригаар

Гариг	Он	1-сар	2-сар	3-сар
Даваа	2016	54	97	163
	2017	54	82	115
	Өөрчлөлт	100	84.5	70.6
Мягмар	2016	60	99	155
	2017	33	61	93
	Өөрчлөлт	55	61.6	60
Лхагва	2016	66	104	146
	2017	26	55	83
	Өөрчлөлт	39.4	52.9	56.8
Пүрэв	2016	33	75	132
	2017	32	64	97
	Өөрчлөлт	97	85.3	73.5
Баасан	2016	48	79	110
	2017	45	84	115
	Өөрчлөлт	93.8	106.3	104.5
Бямба	2016	20	38	65
	2017	33	60	81
	Өөрчлөлт	165	157.9	124.6
Ням	2016	18	33	51
	2017	29	54	81
	Өөрчлөлт	161.1	163.6	158.8

2016 онд нийт гарсан гэмт хэргийн 19.8 хувь нь Даваа гарагт, 18.8 хувь нь Мягмар гарагт, 17.8 хувь нь Лхагва гарагт, 16.0 хувь нь Пүрэв гарагт, 13.4 хувь нь Баасан гарагт, 7.9 хувь нь Бямба гарагт, 6.2 хувь нь Ням гарагт тус тус гарсан байна. Дээрх тооноос харахад ажлын өдрүүдэд ихэвчлэн гэмт хэрэг гардаг бөгөөд 2017 он гарсаар амралтын өдрүүдэд гарсан гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна.

Зураг-5. Гэмт хэргийн тоо, үйлдсэн гарагаар



2017 оны эхний 3 сарын байдлаар нийт гарсан гэмт хэргийн 42 орчим хувь нь гэр, орон сууцанд гарсан бөгөөд үүний 46.2 хувь нь гэрт гарсан гэмт хэрэг байна. 2016 онд нийт гарсан гэмт хэргийн 48.7 хувь нь гэр, орон сууцанд гарч байсан бол 2017 онд гэр, орон сууцанд гарсан гэмт хэрэг 6.7 орчим хувиар буурсан байна.

2017 оны эхний улиралд нийт гэмт хэргийн 19.4 хувь нь гудамж, талбайд гарсан бол 2016 онд 18.5 хувь нь гудамж талбайд гарсан байна. Тайлант хугацаанд нийт гудамж талбайд гарсан гэмт хэргийн 45 орчим хувь нь гэр хороололд гарчээ. Гудамж талбайд гарсан гэмт хэрэг 2017 оны 1, 2-р сард өмнөх оны мөн үеэс өсч байгаад 3 сард буурсан байна.

Хүснэгт 6. Гэмт хэргийн тоо, хэрэг үйлдсэн байршлаар


Үзүүлэлт		Он	1-сар	2-сар	3-сар
Гэр, орон сууцанд бүгд		2016	147	258	400
		2017	95	183	279
		Өөрчлөлт	64.6	70.9	69.8
Үүнээс:	Гэрт	2016	64	99	161
		2017	42	81	129
		Өөрчлөлт	65.6	81.8	80.1
	Орон сууц, байранд	2016	20	40	47
		2017	16	21	34
		Өөрчлөлт	80	52.5	72.3
Гудамж, талбайд бүгд		2016	60	104	152
		2017	74	111	129
		Өөрчлөлт	123.3	106.7	84.9
Үүнээс:	гэр хороололд	2016	22	40	67
		2017	28	48	58
		Өөрчлөлт	127.3	120	86.6
	Орон сууцны хороололд	2016	24	37	48
		2017	29	38	41
		Өөрчлөлт	120.8	102.7	85.4
Олон нийтийн газарт, бүгд		2016	30	57	90
		2017	22	59	81
		Өөрчлөлт	73.3	103.5	90

2017 оны I улиралд олон нийтийн газарт 81 гэмт хэрэг гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 9 гэмт хэргээр буюу 10.0 хувиар буурсан байна.

2017 оны эхний 3 сарын байдлаар гарсан гэмт хэргийн байршилын байдлаас харахад гэр орон сууцанд гарсан хэргийн 46 гаруй хувь, гудамж талбайд гарсан хэргийн 45 орчим хувь нь гэр хороололд гарсан байна. Харин гэр орон сууцанд

гарсан хэргийн 12,2 хувь орон байранд, гудамж талбайд гарсан хэргийн 31,8 хувь нь орон сууцны хороололд гарсан байна.

Зураг-6. Гэмт хэргийн тоо,хэрэг үйлдсэн байршил, хувиар, 2017-3 сард



Хүснэгт 7. Гэмт хэргийн тоо, хэрэг үйлдсэн байдлаар

Үзүүлэлт	Он	1-сар	2-сар	3-сар
Согтуугаар	2016	56	85	127
	2017	40	80	107
	Өөрчлөлт		71.4	94.1
Хүүхэд оролцсон	2016	11	15	19
	2017	6	9	26
	Өөрчлөлт		54.5	60.0
Эмэгтэй оролцсон	2016	27	47	77
	2017	28	49	70
	Өөрчлөлт		103.7	104.3
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	2016	16	34	48
	2017	16	29	41
	Өөрчлөлт		100	85.3
Бүлэглэн	2016	18	31	42
	2017	19	24	34
	Өөрчлөлт		105.6	77.4

2017 оны эхний улиралд гарсан нийт гэмт хэргийн 16.1 хувийг согтуугаар үйлдсэн бол 2016 онд 15.4 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна.Тайлант хугацаанд хүүхэд оролцсон гэмт хэргийн тоо 26 гарсан нь өмнөх оны мөн үеэс 7 гэмт хэргээр буюу 36.8 хувиар өссөн үзүүлэлт байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 6.2 хувь болж байгаа бол 2016 онд 5.8 хувь байсан байна. 2017 онд бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 34 гарсан нь өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны бүлгээр


Насны бүлэг	Он	1-сар	2-сар	3-сар
Бүх хүн	2016	215	385	622
	2017	170	348	536
	Өөрчлөлт	79.1	90.4	86.2
15 хүртэл	2016	1	2	5
	2017	2	3	5
	Өөрчлөлт	200.0	150.0	100.0
16-17	2016	10	13	15
	2017	5	7	22
	Өөрчлөлт	50	53.8	146.7
18-24	2016	50	91	147
	2017	35	83	124
	Өөрчлөлт	70	91.2	84.4
25-29	2016	43	102	148
	2017	53	86	107
	Өөрчлөлт	123.3	84.3	72.3
30-34	2016	51	71	125
	2017	18	44	76
	Өөрчлөлт	35.3	62.0	60.8
35-39	2016	30	42	69
	2017	23	46	72
	Өөрчлөлт	76.7	109.5	104.3
40-44	2016	15	29	53
	2017	15	31	52
	Өөрчлөлт	100	106.9	98.1
45-49	2016	8	14	29
	2017	11	25	40
	Өөрчлөлт	137.5	178.6	137.9
50-54	2016	6	16	23
	2017	5	16	23
	Өөрчлөлт	83.3	100.0	100.0
55-59	2016	0	3	3
	2017	1	4	8
	Өөрчлөлт	0	133.3	2.7 дах
60 дээш	2016	1	2	5
	2017	2	3	7
	Өөрчлөлт	2 дах	150.0	140.0

2017 оны эхний улиралд гэмт хэрэг үйлдсэн нийт хүнээс 18-24 насныхан 23.1 хувь, 25-29 насныхан 19.9 хувь, 30-34 насныхан 14.2 хувь байгаа бол 2016 онд 18-24 насныхан 23.6 хувь, 25-29 насныхан 23.8 хувь, 30-34 насныхан 20.1 хувийг эзэлж байсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүний ихэнх нь 18-35 хүртэлх насны залуучууд байна. 2017 оны байдлаар хэрэгт холбогдсон хүн амын 57.2 хувь нь 18-35 насны залуучууд байна. 2016 онд гэмт хэрэг үйлдсэн хүний 67.5 хувь нь 18-35 насны залуучууд байсан байна.

2017 оны I улиралын байдлаар гэмт хэрэгт холбогдсон 16-17 настай хүний тоо өнгөрсөн оны мөн үеэс 1.7 хувиар, 35-39 насныхан 2.3 хувиар, 40-44 насныхан 1.2 хувиар, 45-49 насныхан 2.8 хувиар, 50-54 насныхан 1.0 хувиар өссөн байна.

Зураг-7. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны бүлэг ,хувиар




Гэмт хэрэг үйлдсэн хүн амын нийгмийн байдлыг харвал 2017 оны эхний улиралд нийт гэмт хэрэг үйлдсэн хүн амын 54.1 хувь нь ажилгүй иргэд байна. Хэрэг үйлдсэн нийт хүн амаас 27 орчим хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 2.6 хувь нь оюутан, 1.7 хувь нь сурагч, 2.6 хувь нь сургууль завсардсан хүүхэд байна.

2016 оны мөн үед 395 ажилгүй иргэн хэрэг үйлдсэн нь нийт хэрэг үйлдсэн хүн амын 63.5 хувь нь байсан байна.

Хүснэгт 9. Гэмт хэрэг үйлдэгсэд, нийгмийн байдлаар

Үзүүлэлт	Он	1-сар	2-сар	3-сар
ТАХ	2016	9	11	18
	2017	5	7	11
	Өөрчлөлт	55.6	63.6	61.1
Хувийн хэвшлийн ажилтан	2016	12	25	33
	2017	16	35	50
	Өөрчлөлт	133.3	140.0	151.5
ТТБ- ажилтан	2016	1	1	6
	2017	3	6	8
	Өөрчлөлт	300	600	133.3
ХХЭ, малчин	2016	12	86	138
	2017	52	97	143
	Өөрчлөлт	433.3	112.8	103.6
Оюутан	2016	10	15	19
	2017	4	6	14
	Өөрчлөлт	40	40	73.7
Сурагч	2016	4	6	10
	2017	2	6	9
	Өөрчлөлт	50	100	90
Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл хүүхэд	2016	0	2	2
	2017	1	10	11
	Өөрчлөлт	0	5 дах	5.5 дах
Ажилгүй	2016	126	238	395
	2017	87	181	290
	Өөрчлөлт	69.0	76.1	73.4

Зураг-8. Гэмт хэрэг үйлдэгсэд, боловсролын түвшин, хувиар



2017 оны эхний улиралын байдлаар гэмт хэрэг үйлдсэн нийт хүн амын 48.1 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. 21.5 хувь нь суурь боловсролтой хүн ам байна.

2016 оны байдлаар бүрэн дунд боловсролтой 296 хүн гэмт хэрэгт холбогдсон нь нийт гэмт хэрэгт холбогдсон хүн амын 47.6 хувь байна. Харин суурь боловсролтой хүн 26.0 хувь байсан байна.

Тайлант хугацаанд гэмт хэрэг хийсэн нийт хүнээс боловсролгүй хүн 3.3 хувь, бага боловсролтой хүн 5.1 хувь байгаа бол дээд боловсролтой хүн 13.4 хувь болж байна.

Хүснэгт 10. Гэмт хэрэг үйлдэгсэд, боловсролын түвшингээр

Боловсролын түвшин	Он	1-сар	2-сар	3-сар
Боловсролгүй	2016	11	12	20
	2017	2	11	22
	Өөрчлөлт	18.2	91.7	110.0
Бага	2016	8	23	43
	2017	8	17	34
	Өөрчлөлт	100	73.9	79.1
Суурь	2016	53	101	162
	2017	37	77	115
	Өөрчлөлт	69.8	76.2	71.0
Бүрэн дунд	2016	108	189	296
	2017	86	179	258
	Өөрчлөлт	79.6	94.7	87.2
ТМС,Тусгай дунд	2016	9	15	25
	2017	7	14	18
	Өөрчлөлт	77.8	93.3	72.0
Дээд	2016	26	45	76
	2017	30	50	89
	Өөрчлөлт	115.4	111.1	117.1

2017 оны эхний 3 сард гэмт хэрэг хийсэн хүнээс дээд боловсролтой гэмт хэрэг хийсэн хүний тоо өмнөх оны мөн үеэс 17,1 хувиар өссөн байна.



Холбоо барих

18082 Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг
27-р хороо Агарын гудамж
Дэлхийн зөн ОУБ-ын байр
Утас: 70171322, 70171660
И-мэйл: Songinokhairkhan@nso.mn
Вэб: www.ubstat.mn
www.shd.mn

